



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 11

Мандалговь

Г  
Н.Лхагва-Учралыг Газрын харилцаа, барилга,  
хот байгуулалтын газрын Цагаандэлгэр  
сумын газрын даамлын албан тушаалд  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Цагаандэлгэр сумын газрын даамлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Нарангэрэлийн Лхагва-Учрал 58.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Н.Лхагва-Учралын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь  
салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын  
20-ны өдрийн 11 дугаар тогтоолын хавсралт



**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын  
Цагаандэлгэр сумын газрын даамлын албан тугаалд  
нэр дэвшүүлсэн Н.Лхагва-Учралын тухай дүгнэлт**

1. Н.Лхагва-Учрал нь 1995 онд Дундговь аймгийн Говь-Угтаал суманд төрсөн. 27 настай, эрэгтэй.
2. Боловсрол: 2014-2018 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг экологи, байгаль хамгаалал мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Н.Лхагва-Учралын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Цагаандэлгэр сумын газрын даамлын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ**